

## Банкны салбарын эргэн тойронд

01.05 – Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар БНХАУ-ын Үйлдвэр Худалдааны банкинд Монгол Улсад Төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгохоор шийдвэрлэлэв. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

01.07 – JICA-аас Худалдаа, хөгжлийн банкыг “2016 оны Шилдэг Санхүүгийн Байгууллага”-аар шалгарууллаа. 2016 онд харилцагчиддаа 6.8 тэрбум төгрөгийн төслийн зээлийг амжилттай олгосон, мөн итгэлцэлтэй харилцааны үр дүнд чанаргүй зээлийн үзүүлэлттэй байгаа үр дүнг үнэлэн дээрх шагналыг олгожээ. [tdbm.mn](http://tdbm.mn)

01.16 – Голомт банк, Автоланд ХХК болон Мөнххада ХХК хамтран Голомт банкны шинэ зээлийн үйлчилгээ болох Автодилерийн үйлчилгээг нэвтрүүлэв. [golomtbank.com](http://golomtbank.com)

01.20 – Худалдаа, хөгжлийн банк 2007 онд анх удаа 75 сая ам.долларын бондыг олон улсын санхүүгийн зах зээлд амжилттай арилжаалж, нийт 1.14 тэрбум ам.долларын бондыг 5 удаа гаргасан. 2014 онд гаргасан 700 сая юанийн буюу 115 сая ам.долларын 3-н жилийн хугацаатай бондыг өөрийн дотоодын эх үүсвэрээр хугацаанд нь амжилттай төлсөн. [tdbm.mn](http://tdbm.mn)

### Бонд

Бонд гэдэг нь Засгийн газар аль эсвэл компаниас төсөл хөтөлбөр, хөрөнгө санхүүжилт босгох гэж гаргасан өрийн бичиг бүхий үнэт цаасыг хэлдэг. Тодорхой тогтоосон хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүгийн хамт эргэн төлдөг.

01.31 – Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит бус хуралдаан 2017 оны 1 дүгээр сарын 27-ий өдөр болов. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

01.31 – Bogd Bank has signed a correspondent banking agreement with VTB Bank, one of the leading commercial banks of Russia. [bogdbank.com](http://bogdbank.com)

02.01 – ХААН Банк нь ‘QRay үйлчилгээ’-г зах зээлд анхлан нэвтрүүллэв. Ингэснээр QR код бүхий нэхэмжлэх өөрийн дансанд үүсгэж бусдаас төлбөр хураалт хийх, QR кодоор хэрэглээний төлбөр болон бусад төлбөрөө төлөх боломжтой болов. [khanbank.com](http://khanbank.com)

02.03 – Татварын Ерөнхий газраас 483 мянган харилцагчийн 34.5 тэрбум төгрөгийн НӨАТ-ын буцаан олголтын мэдээлэл ирүүлснээс Монголбанк 462 мянган харилцагчдад 32.9 тэрбум төгрөгийн гүйлгээг амжилттай гүйцэтгэв. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

02.10 – Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Ипотекийн орон сууцны санхүүжилтийн журмыг 2016 оны аравдугаар сарын 25-нд шинэчлэн баталсан. Шинэ журмын дагуу Монголбанк нь ипотекийн зээлийн санхүүжилтийг ипотекийн зээлээр баталгаажсан бонд оор урьдчилсан байдлаар олгож байна. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

02.20 – Голомт банк нь Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтарч бизнес эрхлэгчдийг дэмжих, хамтдаа хөгжих, зөвлөх үйлчилгээний ач холбогдлыг таниулах, харилцан туршлага солилцох зорилгоор “Бизнесийн зөвлөх үйлчилгээний форум”-ыг амжилттай зохион байгуулав. [golomtbank.com](http://golomtbank.com)


02.24 – Монголбанкны дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хятадын Ардын Банкны дэд ерөнхийлөгч Ий Ганг нар 2017 оны 2-р сарын 22-ны өдөр хэлэлцээр хийж төгрөг, юаний спот хэлцлийг дахин 3 жилийн хугацаатай сунгах тохиролцоонд хүрэв. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

03.17 – Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж, бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргав. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

03.22 – Худалдаа, хөгжлийн банк, БНХАУ-ын Тариалангийн банктай 2002 онд юанийн гадаад төлбөр тооцооны үйлчилгээг Монгол улсад анхлан нэвтрүүлж хамтран ажиллаж эхэлсний 15-н жилийн ойг тохиолдуулан 3-р сарын 17-19-ны өдрүүдэд Эрээн хотноо хамтарсан уулзалт зохион байгуулав. [tdbm.mn](http://tdbm.mn)

## Банкны салбарын гол үзүүлэлтүүд /татан буугдсан банкуудыг хассанаар/

Банкны салбарын актив, их наяд төгрөг



**Нийт актив = 25,2 их наяд төгрөг**

Банкны салбарын нийт актив 2017 оны 1-р улиралд 25,2 их наяд төгрөг болж өмнөх улирлаас даруй 0,1 их наяд төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 3,2 их наяд төгрөгөөр өслөө. 2015 оны 3-р улирлаас хойш нийт актив нь тогтмол өсөж байсан хэдий ч энэ улиралд буурлаа.


Нийт зээл ба чанаргүй зээлийн эзлэх хувь



**Чанаргүй зээл 6,7%-д хүрлээ**

Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2014 оны 2-р улирлаас хойш 2016 оны 3-р улирал хүртэл тогтмол өссөн бол сүүлийн хоёр улирал дараалан буурч 6,7%-д хүрлээ. Нийт дүнгээр авч үзвэл 2017 оны 1-р улиралд нийт чанаргүй зээл 830 тэрбум төгрөг байна.


Ипотекийн зээл, их наяд төгрөг



**Ипотекийн зээл = 4.1 их наяд төгрөг**

Нийт ипотекийн зээл 4,1 их наяд төгрөг хүрсэн бол үүнээс орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (ОСИСТТБ)-н дагуу 3,2 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Ипотекийн зээлийн хэмжээ тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тогтмол өссөөр байна.

Хадгаламж ба харилцах, их наяд төгрөг



**Харилцах+Хадгаламж=11,5 их наяд ₮**

Нийт банкны салбарын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 19.8% буюу 1,9 их наяд төгрөгөөр өссөн бол өмнөх улирлаас 0,1 их наяд төгрөгөөр өсжээ. Харилцах дансны хэмжээ өмнөх улирлаас буурсан хэдий ч хадгаламж илүү их өсжээ.


# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2017 он – I улирал




Валют(Харилцах + Хадгаламж) = 3,6 их наяд ₮

Өмнөх улиралтай харьцуулахад валютын харилцах 7,1%-иар харин валютын хадгаламж 17,29%-иар буужээ. Нийт валютын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 17,6% өсөж 2,6 их наяд төгрөгт хүрээд байна.




1\$=2459₮ 1¥=356₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2017 оны 3-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2459₮, Юань-ийн ханш 356₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.доллар 413₮-р, Юань 42₮-р өссөн үзүүлэлт юм. Валютын ханш сүүлийн хэдэн сар харьцангуй тогтвортой байлаа.



Ашиг = 73 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2017 оны 1-р улирлын байдлаар 3,26 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 27% өслөө. Харин банкны салбарын ашиг оны эхний улирлын байдлаар 73 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн ашгаас 80 тэрбум төгрөгөөр илүү байна.




Банкны нөөц = 2.4 их наяд төгрөг

Банкны нөөц 2016 оны 11 сараас тогтмол буурсаар энэ улиралад 2,4 их наяд төгрөг боллоо. Гэхдээ энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21% өссөн үзүүлэлт юм.



## Онцлох: Хөдөлгөөнт банкны хэрэглээ

Монголбанкнаас улирал тутам гаргадаг “Хөдөлгөөнт банкны тайлан”-ийн онцлох үр дүнг танилцуулъя. 2017 оны 1-р улирлын байдлаар интернэт хандалтын эрхтэй хэрэглэгчийн тоо өнгөрсөн жилийн мөн үеэс 38,5%-иар өсөж 1280772-т хүрлээ. Мобайл хандалтын эрхтэй хэрэглэгчийн тоо өнгөрсөн жилийн мөн үеэс 14% өсөж 1122833-т хүрлээ. Интернэт банкны хэрэглэгчдийн тоо харьцангуй хурдацтай өсөж байна.



Интернэт хандалтаар тухайн банкны салбар хооронд хийгдсэн гүйлгээний тоо, дүн		
	Тоо	Дүн (тэрбум төгрөгөөр)
Мөнгөн хадгаламж	3,169,051	1,980
Зээл	175,644	127
Төлбөр тооцооны үйлчилгээ	4,176,016	308
Гадаад валют	9,387	8
Гадаад төлбөр тооцоо	7,129	104
<b>Нийт</b>	<b>7,537,227</b>	<b>5,303</b>

Нийт 7,5 сая удаагийн интернэт хандалтаар 5,3 их наяд төгрөгийн гүйлгээ хийгджээ. Интернэт гүйлгээний тоо өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад даруй 2 дахин өссөн бол нийт дүн нь 94%-иар өсжээ.

Мобайл хандалтаар тухайн банкны салбар хооронд хийгдсэн гүйлгээний тоо, дүн		
	Тоо	Дүн (тэрбум төгрөгөөр)
Мөнгөн хадгаламж	648,686	1,980
Зээл	20,236	127
Төлбөр тооцооны үйлчилгээ	1,490,978	308
Гадаад валют	303	8
<b>Нийт</b>	<b>799,837</b>	<b>3,113</b>

Нийт 8 сая удаагийн мобайл хандалтаар 3,1 их наяд төгрөгийн гүйлгээ хийгджээ. Мобайл гүйлгээний тоо өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 33%-иар өссөн бол нийт дүн нь 2,7 дахин өсжээ.

## Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2017 оны 1-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал болон Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.



### АКТИВ

### БАНКУУД


ТОМ-3 БАНК	>3 их наяд төгрөг	Худалдаа хөгжлийн банк Хаан банк Голомт банк
ДУНД-3 БАНК	1-3 их наяд төгрөг	Хасбанк Төрийн банк Улаанбаатар хотын банк
БУСАД БАНКУУД	<1 их наяд төгрөг	Капитал банк Чингис хаан банк Капитрон банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк Ариг банк Богд банк Кредит банк Тээвэр хөгжлийн банк

## АКТИВ


Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт актив 24.4 их наяд төгрөгт хүрэв. Том-3 банк нийт активын 71,3%, Дунд-3 банк 23,6%, жижиг банкууд 5,1 хувийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад Том-3 банкны актив 19%, Дунд-3 банкны актив 14%, жижиг банкуудын актив 55% тус бүр өсчээ. Хаан банк 6,57 их наяд төгрөгийн активтай хамгийн өндөр нь байгаа бол Кредит банк хамгийн бага буюу 17 тэрбум төгрөгийн активтай байна.


Зах зээлд эзлэх хувь, активаар, 1У'17



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь



Жижиг банкууд




## ЗЭЭЛ

Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт зээл 11,9 их наяд төгрөг байна. Үүнээс 70.4%-г Том-3 банк, 24.8%-г Дунд-3 банк, 4.8%-г жижиг банкууд бүрдүүлж байна.


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 7%-иар, Дунд-3 банк 9%-иар, жижиг банкууд 31%-иар тус тус зээлийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ 8% өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 1У'17




## Зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь


Том-3, тэрбум төгрөгөөр



Дунд-3, тэрбум төгрөгөөр



Жижиг банкууд




## ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ



Тайлант хугацаанд тайланд орсон нийт 12 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 12,8 их наяд төгрөг байна. Үүнээс 69,9%-г Том-3 банк, 24,7%-г Дунд-3 банк, 5,4%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 23%-иар, Дунд-3 банк 10%-иар, жижиг банкууд 93%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл 21,7%-иар өсчээ.


Зах зээлд эзлэх хувь, 1У'17



## Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



## Жижиг банкууд, тэрбум төгрөгөөр






## АШИГ

2017 оны 1-р улирлын байдлаар тайланд орсон 12 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 78 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах дүн) ажиллажээ. Өмнөх оны мөн үед алдагдалтай ажиллаж байсан ХХБ энэ улиралд 31 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Тайланд орсон 12 банкны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58 тэрбум төгрөгөөр илүү ашигтай ажиллаж байна.

Банкуудын ашиг, алдагдал:



### Эх үүсвэр:

1. Статистикийн бюллетень 1У'17, Монголбанк
2. Ипотекийн зээлийн тайлан 1У'17, Монголбанк
3. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 1У'17, Монголбанк
4. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
5. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 1У'17